



# АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2023 ОНЫ 11-Р САР

МОНГОЛ ДАХЬ АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

Зохиогчийн эрх © Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим ("АмЧам Монгол")-ын Уул уурхай, дэд бүтэц, хүнд үйлдвэрийн хорооны болон Хуулийн ажлын хэсгийн гишүүд Бодлого хариуцсан захирал Г. Жавхлантагсийн удирдлага дор боловсруулсан болно.

Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам Монгол-оос зөвшөөрөл авна.

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

2023 оны 11 дүгээр сар  
Улаанбаатар хот

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ашигт малтмалын тухай хуулийн төсөл нь хөрөнгө оруулагчдын анхааралтай ажиглаж буй цөөн хэдэн чухал хуулиудын нэг билээ. Ашигт малтмалын тухай хуулийг анх 2006 онд батлан гаргасан. Сүүлийн жилүүдэд хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалт эрс өөрчлөгдөж, уул уурхайн салбар уналтын мөчлөгтэй тулгарсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) ашигт малтмалын салбартай холбоотой бусад хууль тогтоомжийн зөрчил, давхцлыг арилгах зорилгоор цогц хууль тогтоомж боловсруулахаар ажиллаж байна. УУХҮЯ нь хуулийн төслийн талаар 2023 оны 3 дугаар сараас эхлэн цуврал хэлэлцүүлгийг зохион байгууллаа. АмЧам Монгол Улс Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын англи хэл дээрх хувилбарыг гишүүддээ хүргүүлж, хуулийн төсөлтэй холбогдуулан 16 зарчмын болон бодлогын санал болон тодорхой зүйл, заалтуудтай холбоото нийт 120 санал ирүүлж, УУХҮЯ-наас зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэгт идэвхитэй оролцсон билээ.



2023 оны 10-р сард "Уул уурхайн долоо хоног"-ийн үеэр АмЧам "Монгол Улс чухал ач холбогдол бүхий ашигт малтмалын салбарт аль хэр чухал байр суурьтай вэ?" хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлэгт АмЧам Монголын Бодлого хариуцсан захирал Г. Жавхлантөгс ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулагчдад тулгамдаж буй гол асуудлууд болон

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгахаар дэвшүүлсэн саналуудын талаар танилцууллаа.

**Энэхүү хэлэлцүүлгийн үеэр бидний зүгээс бодлого боловсруулагчдад хүргэсэн бусад гол мессеж бол "Монгол улсын хувьд хамгийн сайн PR бол одоогийн хөрөнгө оруулагчдын амжилтын түүх юм".** Иймд Монгол Улс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг шинэчлэх, одоогийн хөрөнгө оруулагчдыг амжилттай ажиллуулах, тэднийг дэмжих, сонсох, тэдний санал хүсэлтийг шийдвэрлэх замаар хувийн хэвшилд тулгуурласан уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд чадах бүхнээ хийх ёстой. Мөн энэ 10 сарын эхээр Монгол Улсын Засгийн газар болон манай танхимын гишүүн Орано компанийн төлөөллүүд Зөөвч овооны ураны ордын төслийг ашиглах протоколд гарын үсэг зурсныг АмЧам Монгол сайшааж байна. Төсөлд 30 жилийн хугацаанд 1.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. АмЧам Монгол нь гуравдагч хөршийн гишүүдийн энэхүү чухал хөрөнгө оруулалтын гэрээг Монголд "Дараагийн Оюутолгой"; төсөл хэмээн зүйрлүүлж, идэвхтэй сурталчилж байна.



Түүнчлэн 11 дүгээр сарын 9-ний өдөр АмЧам Монголын Уул уурхай, хүнд үйлдвэрийн хороо Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Мэндбаярыг хүлээн авч уулзлаа. Тэрээр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Түүний танилцуулгын дараа Бодлого, нөлөөлөл хариуцсан захирал Г. Жавхлантагс хуулийн төсөлтэй холбогдуулан АмЧам Монголоос гаргасан гол саналуудыг танилцуулж, мөн хорооны гишүүд нэмэлт, өөрчлөлтийн талаар санал, бодлоо хуваалцсан билээ.



Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заавал тусгах шаардлагатай АмЧам Монголын саналууд Монгол дахь Америкийн Худалдааны Танхимаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ажлын хэсгээс боловсруулсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (цаашид "Төсөл" гэх)-д дараах саналуудыг хүргүүлсэн болно.

Саналуудыг дараах үндсэн 2 хэсэгт ангилав. Үүнд:

- 1) Зарчмын болон бодлогын шинж чанартай саналууд.
- 2) Тухайлсан зүйл заалттай холбоотой саналууд.

## **ЗАРЧМЫН БОЛОН БОДЛОГЫН САНАЛУУД**

### **1. Тусгай зөвшөөрлийн төлбөр**

Хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн төлбөрийг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэхээр тусгасан байна. Энэ нь одоогийн байдлаар 50-аас дээш хувьтай байгаа татварын бодит хувь хэмжээг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай бөгөөд бусад үйлдвэрлэгч улс орнуудтай харьцуулахад өрсөлдөх чадваргүй болоход хүргэх юм. Засгийн газрын хувьд зах зээлийн үнийн өсөлтөөс бий болох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх сонирхол байгааг бид ойлгож байгаа хэдий ч хэрэглэж буй хувь, хэмжээ нь зах зээлийн өмнөх нөхцөл байдлыг харгалзан үзсэн байх шаардлагатай юм.

### **2. Ашигт малтмалд агуулагдаж байгаа эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалд оноох АМНАТ**

41.7. "Ашигт малтмалд агуулагдаж байгаа үндсэн болон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын агуулга тус бүрт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ зүйлд заасан журмын дагуу тооцон ногдуулна" гэснийг өөрчлөх. Дагалдах элементэд АМНАТ ногдуулахдаа "эдийн засгийн ач холбогдол бүхий" гэдгийг шалгуур болгох ёсгүй, харин худалдан борлуулсан буюу борлуулалтын орлого хүлээн авсан тохиолдолд ногдуулна гэж тусгах нь илүү оновчтой байна.

"Эдийн засгийн ач холбогдол бүхий" гэсэн тодорхойлолтын дагуу АМНАТ ногдох эсэх дээр маргаан үүсэх өндөр эрсдэлтэй юм. Ашиглаагүй, худалдан борлуулаагүй буюу орлого олоогүй байхад АМНАТ ногдуулах үндэслэлгүй. "Ашигт малтмалд агуулагдаж байгаа үндсэн болон эдийн засгийн ач холбогдол бүхий" гэдгийг хасах, оронд нь "худалдсан" гэдгийг нэмэх.



### **3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд**

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордтой холбоотой одоогийн хуулийн зохицуулалтууд нь үндсэндээ хэвээрээ байхаар томъёолсон байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг уул уурхайн салбарт татахад энэхүү одоо үйлчилж буй бодлого хир зохимжтой бэ гэдгийг дахин авч үзэх нь зүйтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тодорхойлолт нь харьцангуй ерөнхий байдлаар тодорхойлогдсон. Хэдийгээр тодорхой болгосон үзүүлэлт буюу "ДНБ-ний 5 хувиас дээш хэмжээний гэж" оруулж өгсөн боловч нөгөө талаар "үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний" гэсэн харьцангуй ерөнхий шалгуур байгаа тул УИХ, Засгийн газар нь ямар ч орд газрыг стратегийн ордын жагсаалтад оруулах боломжтой байгаа нь дундаж болон томоохон хэмжээний төсөлд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдад тодорхой эрсдэлийг бий болгосоор байна. Иймд нэр томъёог аль болох тодорхой болгох, эсвэл стратегийн ордтой холбоотой зохицуулалтыг аль болох уян хатан болгох, тухайлбал төрийн оролцоо байх эсэх, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах эсэхийг шийдэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчмийн саналыг харгалзах.

### **4. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой татварын зохицуулалт**

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө шилжүүлэх байдлаар тухайн этгээдийн эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар ногдох орлогоосоо 10 хувийн татвар төлж байгаа. Албан татвар ногдуулах, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлалыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулж байгаа бөгөөд хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд адилхан зарчим үйлчилж байгааг харгазлан үзэх. Ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд одоо байгаа зохицуулалтыг хэвээр хадгалж, харин хайгуулын тусгай зөвшөөрлийн хувьд харьцангуй уян хатан болох нь зүйтэй болов уу.

### **5. Эрлийн үйл ажиллагаа**

Ашигт малтмалын эрлийн үйл ажиллагааг ашигт малтмалын хайгуул хийх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд бие даасан үе шат хэлбэрээр Төсөлд оруулсан байна. Одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй АМТХ-д эрлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлж болохоор заасан бол шинэчилсэн найруулгын Төсөлд ашигт малтмал эрэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж болох тухай, мөн аж ахуйн нэгжүүд нь эрлийн ажил эрхлэх хүсэлт илгээсний дараа ашигт малтмалын нөөцтэй байж болзошгүй талбайд хувийн хөрөнгөөр эрлийн ажлыг гүйцэтгэж болохоор тусгасан байна.



Хэдийгээр энэхүү шинээр оруулж ирсэн эрлийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл шаардагдахгүй, нөгөө талаас аливаа гэрээ хийхгүй байна гэж заасан боловч илүү шат дамжлага гаргах байдлаар сөрөг үр дагавар гаргах эсэх, эсвэл илүү нээлттэй, уян хатан, шуурхай болгох буюу эерэг үр дагавар гаргах эсэх нь тодорхой биш байна. Иймд Эрлийн ажлыг зохицуулсан салбарын багц дүрмээс шууд хамаарахаар, нөгөө талаас аль болох сөрөг үр дагавар гаргах, нэмэлт шаардлага бий болгохгүй байх талаас нь анхаарах.

## **6. Газар ашиглах зөвшөөрөл, тусгай зориулалтын эрхийг олгох**

Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд газар ашиглах зөвшөөрөл, тусгай зориулалтын эрхийг олгоход орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд хэрхэхийг тодорхой заагаагүй байна. Эрх мэдлийн хуваарилалт тодорхойгүй байдал болон дүрэм журмыг төрийн түвшин бүрд ялгаатайгаар тайлбарлаж, хэрэглэж байгаа нь хөрөнгө оруулагчид хуулиар олгогдсон эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж болзошгүй.

## **7. Хуучин болон шинэ хуулийн хоорондын шилжилт, хуулийн зөрүүтэй ойлголт**

Хуулийн төслийг одоогийн бичигдсэн хувилбарт хуучин болон шинэ хуулийн хооронд шилжилт хэрхэн хийх зохицуулалт байхгүй байна. Хуулийн төслийн аль нэг заалт одоо явж байгаа төслүүдэд буцаан үйлчлэх эсэхийг тодруулах шаардлагатай. Хууль хэрэгжүүлэгчид төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хуулийн зөрүүтэй ойлголтыг ашиглан хуулиар олгогдсон эрх мэдлээсээ давсан дүрэм журмыг гаргах боломжийг олгодог.

## **8. Хөрөнгө оруулалтын гэрээний талаарх зохицуулалт**

Ашигт малтмалын тухай хуулиар хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийх болон уг гэрээг байгуулахтай холбоотой аливаа харилцааг зохицуулдаггүй бөгөөд уг харилцааг Хөрөнгө оруулалтын тухай хуулиар зохицуулж байна.

Харин цацраг идэвхт ашигт малтмалын хөрөнгө оруулалтын гэрээний тухайд Цөмийн энергийн тухай хуульд харьцангуй өөр зохицуулалтыг тусгасан. Цөмийн энергийн тухай хуульд цацрагт идэвхт ашигт малтмалыг хайх, олборлох үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээг цөмийн түлш, цөмийн түлшний түүхий эдтэй болон цөмийн бодистой харьцдаг цөмийн байгууламжийг ашиглах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээтэй адилхан үзэж, зохицуулсан.

Үйл ажиллагааны онцлог шинж чанар болон эдгээр үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг харгалзан ялгаатай байдлаар зохицуулах шаардлагатай юм.



Түүнчлэн Цөмийн энергийн тухай хуульд хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийх болон түүнийг байгуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй, харин Хөрөнгө оруулалтын тухай хууль болон түүний дагуу баталсан журамд уг хуулийн зохицуулалтад хамаарах хөрөнгө оруулалтын гэрээний талаар нарийвчилсан зохицуулалт хийсэн байдаг.

Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуульд өөр өөр зохицуулалт байгаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчид болон Засгийн газрын эрх ашгийг хөндсөн хоёр чухал асуудал үүсэж байна.

**Нэгдүгээрт**, Цөмийн энергийн тухай хуулийн 30.1 дүгээр зүйлд энэ хуулийн 15.1.2, 15.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болно гэж заасан. Мөн хуулийн 30.2 дугаар зүйлд энэ хуулийн 30.1-д заасан гэрээг 10 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно гэж заасан.

Цөмийн энергийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа 10 хүртэл жил байх болон түүнийг цаашид сунгаж болох хугацааны талаарх зохицуулалт нь уул уурхайн төслийн хугацаатай уялдахгүй байна. Хөрөнгө оруулалтыг олж авахын тулд хөрөнгө оруулагчдын хувьд төслийн нийт хугацааны туршид ойлгомжтой, тодорхой байдал болон хууль эрхзүйн орчин болон татварын тогтвортой орчин байх ихээхэн чухал ач холбогдолтой байдаг.

Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа болон түүнийг сунгах хугацаа нь хамгийн багадаа ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаатай уялдсан байх, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тохиолдолд автоматаар сунгагддаг байх шаардлагатай юм. Энэ нь бусад томоохон уул уурхай болон дэд бүтцийн төслүүдийн олон улсын жишигт нийцэх юм.

**Хоёрдугаарт**, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох журамд заасан хэлэлцээ хийх болон гэрээг байгуулах процессын ажиллагаа цацраг идэвхт ашигт малтмалын хөрөнгө оруулалтын гэрээнд хамаардаггүй. Хөрөнгө оруулалтыг татах үүднээс эдгээрийг Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгах нь гадаадын хөрөнгө оруулагчид болон Засгийн газарт илүү таатай зохицуулалт болох юм.

Бид дээрх хоёр тодорхойгүй бөгөөд бусад ойлгомжгүй асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээ нь цацраг идэвхт ашигт малтмалыг оролцуулан бүхий л ашигт малтмалд хамаарах тухай тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн, Цөмийн энергийн тухай хуульд Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээнд тавигдах шаардлагууд болон процессын ажиллагаа нь Цөмийн энергийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасан үйл ажиллагаанд хамаарна гэсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй юм.





## 9. Үүргээ биелүүлэх баталгаа

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тухайн жилийн зардлынхаа 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн банкны дансанд байршуулах үүрэгтэй.

Мөн Цөмийн энергийн тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон мөнгөн хөрөнгө байршуулах үүрэгтэй. Гэсэн хэдий ч уг мөнгөн хөрөнгийн хэмжээг өнөөдрийг хүртэл тогтоогоогүй байна.

Иймд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тодорхой болгох үүднээс дээрх мөнгөн хөрөнгийн хэмжээг тодорхой болгох шаардлагатай байна.

Түүнчлэн дээрх мөнгөн хөрөнгийг Засгийн газраас нээсэн дансанд бус, арилжааны банкинд байршуулах эсхүл банкны тусгай баталгаагаар баталгаажуулах, мөн уг мөнгөн хөрөнгийг хүү тооцох ам.долларын дансанд байршуулах боломжуудыг судлах, авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд заасан хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийн талаарх шинэ зохицуулалттай холбоотойгоор уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах баталгаа бөгөөд уурхайн хаалтын үе шатанд буцаан олгогддог дээрх мөнгөн хөрөнгийг байршуулах шаардлагагүйгээр зохицуулах боломжтой юм. Бид Ашигт малтмалын тухай хуульд уурхайн хаалтын үе шатанд байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд заасан ганцхан төрлийн санхүүжилт буюу мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг тусгах саналтай байна.

## 10. Уурхайн хаалтын үйл ажиллагааны санхүүжилт

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэг чухал бол үйлдвэрлэлийн хугацаа дуусахад хаалтын үйл ажиллагаа болон нөхөн сэргээлтийн нийт зардал бүрэн санхүүжигдэх явдлыг хангах явдал байдаг. Гэвч энэ асуудлыг Цөмийн энергийн тухай хуульд тодорхой зохицуулаагүй. Практикт үйлдвэрлэлийн үе шатны туршид хаалтын үйл ажиллагаа болон нөхөн сэргээлтийн зардлыг тусгайлан байршуулах замаар үйлдвэрлэлийн хугацаа дуусахад хаалтын үйл ажиллагаа болон нөхөн сэргээлтийн нийт зардал бүрэн санхүүжигдэх явдлыг хангадаг.



Дээрх зарчмын саналуудаас гадна хуулийн төслийн тухайлсан зүйл заалттай холбоотой 83 саналыг АмЧам Монголын зүгээс хуулийн ажлын хэсэгт хүргүүлсэн билээ.

Эцэст нь дүгнэхэд, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хөрөнгө оруулагчдад ээлтэй, олон улсын стандарт, хэм хэмжээнд нийцүүлэхийн тулд бидний саналыг тусгах шаардлагатай гэж АмЧам Монгол үзэж байна. Мөн энэхүү хуулийн төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулан, сайтар хэлэлцэж, шуурхай батлан гаргахыг уриалж байна.

